



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/410

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/254 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх УТ2003900181 дугаар төслийн кодтой "Ахмадын холбоо, сувиллын барилга" угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Я.Жаргалцэцэг (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: Р.Пүрэвдорж (Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн)  
А.Доржготов (Иргэний нийгмийн төлөөлөл) (тохиролцсоноор)  
Ж.Мөнхцэцэг (Иргэний төлөөлөл) (тохиролцсоноор)

Нарийн бичиг Д.Нарандулам (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Я.Жаргалцэцэг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

8200011037

